



ЦАХИМ ТӨЛБӨРИЙН БАРИМТЫН СИСТЕМ

(Гарын авлага-Хойшлогдсон худалдан авалтын падаан)

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

АГУУЛГА

- 1.НӨАТ суутган төлөгчөөс авсан дотоодын худалдан авалт, гаалийн мэдээг хойшлуулан тайлагнах 3
2. Нягтлан бодох бүртгэлд тусгах.....4

1. НӨАТ суутган төлөгчөөс авсан дотоодын худалдан авалт, гаалийн мэдээг хойшлуулан тайлагнах

ХЭРЭГЛЭЭ:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.4-д “тайлант хугацааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралгүй импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ”-г төсөвт төлөх албан татвараас хасахгүй гэж заасан. Хэрэв дотоодын зах зээлээс худалдан авсан, импортолсон бараа, ажил, үйлчилгээ нь тайлант сард хэрэгжиж борлуулалтын орлого болоогүй бол худалдан авалтын хасалтыг хийхгүйгээр хойшлуулан, хамаарах сард хасагдуулга хийнэ.

АЛХАМ-1

ХИЙХ ҮЙЛДЭЛ:

Цахим төлбөрийн баримтын системийн НӨАТ-ын падаан цэсний худалдан авалтын падаанаас “НӨАТ суутган төлөгчид гарсан”, “гаалийн мэдээ” хэсгээс тухайн тайлант сард хасагдахгүй падааныг сонгон “Хойшлогдсон падаан үүсгэх” товчийг даран шилжүүлнэ.

/Зураг№01/

	№	Падаан №	ДДТД	Огноо	Харилцагч	НӨАТ	Нийт дүн
<input checked="" type="checkbox"/>	1	20033311	000099119913200409001000936	2020-04-07	()	31,735.78₮	349,093.53₮
<input checked="" type="checkbox"/>	2	Амжилттай шилжлээ		2020-04-07	()	14,806.18₮	162,867.98₮
<input type="checkbox"/>	3	20033309	000099119913200409001000934	2020-04-07	()	7,583.68₮	83,420.43₮

ГАРАХ ҮР ДҮН:

Таны шилжүүлсэн падаан “Хойшлогдсон худалдан авалтын падаан”-ы жагсаалтад нэмэгдэнэ.

АЛХАМ-2

ХИЙХ ҮЙЛДЭЛ:

НӨАТ-ын падаан цэсийн “Хойшлогдсон худалдан авалтын падаан”-ы жагсаалт руу ороход тухайн сард хойшлууулсан падааны жагсаалт харагдах бөгөөд татвар төлөгч та тухайн падааны хойшлуулан тайлагнах үйлдлийг буцаах болон тайланд тусгах боломжтой. Тухайн шилжүүлсэн падаан нь тайлант сарын худалдан авалтын дүнгээс хасагдахгүй бөгөөд суутган төлөгч нь хасагдах сар болоход падааны “тайлагнах” товчийг дарснаар тайлант сарын худалдан авалт хэсэгт тайлагнагдана.

НӨАТ суутган төлөгчид гарсан Гаалийн мэдээ НӨАТ-с чөлөөлөгдөх Хувь тэнцүүлэн хасагдуулах падаан жагсаалт							
Хойшлогдсон худалдан авалтын падаан							
№	Падаан №	Төрөл	Огноо	Харилцагч	НӨАТ	Нийт дүн	Шилжүүлсэн огноо
1	20033311	Хойшлуулсан падаан	2020-04-07	()	31,735.78₮	349,093.53₮	2020-06-25
2	20033310	Хойшлуулсан падаан	2020-04-07	()	14,806.18₮	162,867.98₮	2020-06-25
						46,541.96₮	511,961.52₮

Буцаах

- Хойшлуулсан падааныг буцаах.

Тайлагнах

- Тайланд тусгах боломжтой бөгөөд тусгах сараа сонгоно. /Зураг№04/

Хойшлуулсан падаан хасагдуулах ✕

Тусгах сараа сонгоно уу

5 сар 6 сар

Та **20033311** дугаартай хойшлуулсан падаан хасагдуулахдаа итгэлтэй байна уу?

АНХААРАХ ЗҮЙЛ:

- Тайланд тусгах сар нь тухайн баримт хэвлэгдсэн сараас өмнө байж болохгүй.
- Гаалийн мэдээ дахин татахад “Хойшлогдсон худалдан авалтын падаан”- ы жагсаалтад орсон мэдээнээс бусад мэдээ татагдана.

ГАРАХ ҮР ДҮН:

Падааныг хойшлуулснаар худалдан авалт хийсэн сарын НӨАТ суутган төлөгчийн тайлангийн Худалдан авалтын бүртгэлийн мэдээ ТТ-03а-5, гаалийн мэдүүлэг ТТ-03а-7-д татагдахгүй ба харин тухайн падааны тайлагнах сарын мэдээ тайланд тусгагдах болохыг анхаараарай.

Хувь тэнцүүлэн хасагдах падаан

НӨАТ суутган төлөгчид гарсан Гаалийн мэдээ НӨАТ-с чөлөөлөгдөх Хувь тэнцүүлэн хасагдуулах падаан жагсаалт

Хойшлогдсон худалдан авалтын падаан

№	Падаан №	Төрөл	Огноо	Харилцагч	НӨАТ	Нийт дүн	Шилжүүлсэн огноо	
1	4076980164	Хойшлогдсон падаан	2020-01-09	Содмонгол групп (2577739)	27,709.09₮	304,800.00₮	2020-06-01	Хасах
							27,709.09₮	304,800.00₮

« < 1 > »

АНХААРАХ ЗҮЙЛ:

Суутган төлөгч нь тухайн хойшлуулсан падааны тайлагнах үйлдлийг буцаахдаа “хасах” товчийг дарснаар үйлдэл буцна.

2. Хойшлуулсан падааныг нягтлан бодох бүртгэлд тусгах

Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн дотоодын зах зээлээс болон импортоор худалдан авахад төлсөн албан татварыг тайлант хугацааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралгүйгээр хийгдсэн худалдан авалтад төлсөн бол татвар төлөгч тухайн худалдан авалтын тайлагналыг хойшлуулан, хэрэгжсэн сарын албан татвар суутган төлөгчийн тайланд тусгана.

Жишээ-1: Хан-Уул дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй суутган төлөгч “ГГГ” ХХК-нь 2020 оны 01 дүгээр сард худалдан борлуулах зорилгоор дотоодын зах зээлээс 11’000’000 төгрөгийн үнийн /НӨАТ-тэй/ дүнтэй автомашины сэлбэг худалдаж авсан. Тухайн сэлбэгийг “ГГГ” ХХК-ны 2020 оны 06 дугаар сард 14’300’000 төгрөгөөр /НӨАТ-тэй/ заржээ. Тэгвэл тус компани дээрх худалдан авалтыг нь 2020 оны 01 дүгээр сарын суутган төлөгчийн тайланд тусгахгүйгээр “Хойшлогдсон худалдан авалтын падаан” рүү шилжүүлэх ба худалдан авалтын хэрэгжсэн сар буюу 6 сарын тайланд хойшлуулан хасалт хийнэ.

Нягтлан бодох бүртгэлийн журналын бичилт:

2020 01 сард:

Дансны нэр	Дт	Кт
Бараа материал	10’000’000	
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	1000’000	
Мөнгө		11’000’000

2020 06 сард:

Дансны нэр	Дт	Кт
Мөнгө	14’300’000	
Борлуулалтын орлого		13’000’000
НӨАТ-ын өглөг		1300’000
ББӨ	10’000’000	
НӨАТ-ын авлага	1000’000	
Бараа материал		10’000’000
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		1000’000